

**СТРАТЕГИ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ЦАХИМ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ Ч.БОЛОР-ЭРДЭНИЙН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Эхлэх, дуусах хугацаа	Биелэл- тийн хувь	
				Хүрсэн түвшин			
1	2	3	4	6	7		
Зорилт 1. “ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ”							
1.	Арга хэмжээ 1.1. Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний № 2.1. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо 1	Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн схем зургийн төсөл хийгдсэн.	<p>Дэлхийн ДНБ-ний 80%, ОУ-ын худалдааны 75%, Дэлхийн хүн амын гуравны хоёр (2/3), Дэлхийн газар нутгийн 60%-ийг эзэлдэг G7, G20-д багтдаг Европын холбооны гишүүн 40-өөд улсын мөрддөг баримт бичиг болох:</p> <ul style="list-style-type: none"> • Европын харилцан уялдааны тогтолцооны архитектур • Европын харилцан уялдааны тогтолцоо • Европын харилцан уялдааны тогтолцооны лавлагагаа • Европын цахим эрх ба зарчим • Европын харилцан уялдааны архитектурыг хөгжүүлэх үйл ажиллагаа • Эстони Улсын X-Road системийн тухай • Европын дижитал 10 жилийн хөтөлбөр(The European Digital decade program-2030) • Олон Улсын эдийн засаг, хөгжлийн агентлагаас гаргасан Цахим засаглалын бодлогын хүрээ зэрэг баримт бичгүүдийг судлан танилцуулга бэлтгэж, нэгжийн даргад болон сайд (нэгжийн дарга)-д танилцуулсан. 	09.01 12.15	100	

				Mөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн систем, дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн систем болон мэдээллийн сүлжээ, нийтийн мэдээллийн сангийн хэрэглээ, түүний ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн зураглалыг гаргаж, нэгдсэн зөвлөмж, заавар боловсруулах зорилготой тендерийн ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг тус тус боловсруулж, уг тендерийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан.		
Дэд арга хэмжээ 1.1.1. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах ажлын даалгавар боловсруулж, тендер зохион байгуулна.	Батлагдсан ажлын даалгаврын тоо -1	0	1. "Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах" төслийн ажлын даалгаврыг боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. 2. Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах" ЦХИХХЯ/20250103058, "Төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд цахим гэрээг нэвтрүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх (нотариат) судалгаа" ЦХИХХЯ/20250203039 дугаартай үйлчилгээний тендер шалгаруулалтыг тус тус зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороо байгуулах тушаалын төслийг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын "Үнэлгээний хороо байгуулж, зардал гаргах тухай" 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/146 дугаар тушаалыг батлуулсан. 3. "Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах" ЦХИХХЯ/20250103058 дугаартай тендерийн баримт бичгийг боловсруулах үнэлгээний хороонд ажиллаж, тус тендерийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр	03.15 05.26	100	

			нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан болно.		
	Дэд арга хэмжээ 1.1.2. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төслийг боловсруулж, холбогдох газруудаас санал авч нэгтгэнэ.	Боловсруулагдсан баримт бичгийн тоо-2	Төслийн эхний хувилбар боловсруулагдсан.	Тайлант хугацаа болоогүй	08.05 09.10 Үнэлэх хугацаа болоогүй
	Дэд арга хэмжээ 1.1.3. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төслийн нөлөөллийн шинжилгээг боловсруулна.	Боловсруулсан баримт бичгийн тоо-2	0	Тайлант хугацаа болоогүй	09.15 10.01 Үнэлэх хугацаа болоогүй
	Дэд арга хэмжээ 1.1.4. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төслийн танилцуулга, холбогдох бусад мэдээллийг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх хүсэлтийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Боловсруулсан баримт бичгийн тоо-4	0	Тайлант хугацаа болоогүй	10.05 12.15 Үнэлэх хугацаа болоогүй
2.	Арга хэмжээ 1.2. Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний № 2.2. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийг боловсруулж, Засгийн	Хүргүүлсэн баримт бичгийн тоо 1	0	Тайлант хугацаа болоогүй	09.01 12.15 Үнэлэх хугацаа болоогүй

	газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.					
	Дэд арга хэмжээ 1.2.1. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийг боловсруулж, холбогдох газруудаас санал авч нэгтгэнэ.	Боловсруулагдаан баримт бичгийн тоо-2	Төслийн эхний хувилбар боловсруулагдаан	Тайлант хугацаа болоогүй	08.05 09.10	Үнэлэх хугацаа болоогүй
	Дэд арга хэмжээ 1.2.2. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийн нөлөөллийн шинжилгээг боловсруулна.	Боловсруулсан баримт бичгийн тоо-2	0	Тайлант хугацаа болоогүй	09.15 10.01	Үнэлэх хугацаа болоогүй
	Дэд арга хэмжээ 1.2.3. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийн танилцуулга, холбогдох бусад мэдээллийг боловсруулан Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх албан хүсэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Боловсруулсан баримт бичгийн тоо-4	0	Тайлант хугацаа болоогүй	10.05 12.15	Үнэлэх хугацаа болоогүй
3.	Арга хэмжээ 1.3. Газрын гүйцэтгэлийн төлөөлөгөөний № 2.3. Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе	Цахим хэлбэрт шилжүүлсэн зөвшөөрлийн тоо	237	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэлээр “Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, цахим хэлбэрт шилжүүлэх, холбогдох захиргааны хэм хэмжээний актуудыг хуульд нийцүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын	01.15 12.15	100

	шаттайгаар цахимжуулна.			холбогдох гишүүд, албан тушаалтанд үүрэг даалгавар өгөгдсөн.		
	Дэд арга хэмжээ 1.3.1. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах талаар шийдвэрийн төсөл боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хургуулна.✓	Засгийн газрын хуралдааны шийдвэрийн тоо-1	1	Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой өнөөгийн нөхцөл байдлын талаарх танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг ЗГХЭГ-ын Цахим засаглалын хэлтсийн дарга Б.Билэгдэмбэрэлтэй хамtran боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хуралдаанд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулсан.	03.15 04.15	100
	Дэд арга хэмжээ 1.3.2. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг холбогдох газар, нэгжтэй хамtran зохион байгуулна.	Хамtran зохион байгуулсан ажил, арга хэмжээний тоо 1	0	Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлснээр 2025 оны II улирлын байдлаар "license.mn"-ээр 76, "e-business.mn"-ээр 44, эрх бүхий байгууллага өөрийн системээр 123, уламжлалт буюу цаасан хэлбэрээр 16 тусгай зөвшөөрлийг олгож, зөвшөөрлийн нэгдсэн санд 151746 нэгж зөвшөөрлийн мэдээлэл бүртгэгдсэн байна.	07.16 12.15	Үнэлэх хугацаа болоогүй
4.	Арга хэмжээ 1.4. Газрын гүйцэтгэлийн төлөөлөгөөний № 2.4. Нотариатын үйл ажиллагааг үе шаттай сайжруулна.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо 1	0	Нотариатын үйл ажиллагаа, үйлчилгээний өнөөгийн байдал, түүнийг цахим хэлбэрт шилжүүлэхэд тулгарч байгаа хүндэрэл бэрхшээлийн талаарх суурь судалгааг эхлүүлсэн байна.	01.15 12.15	100
	Дэд арга хэмжээ 1.4.1. Төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд цахим гэрээг нэвтрүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх (нотариат) судалгаа" ЦХИХХЯ/20250203039 дугаартай төслийн ажлыг даалгавар болон тус тендерийг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороо байгуулах тушаалын төслийг тус тус боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын "Үнэлгээний хороо байгуулж, зардал	Батлагдсан ажлын даалгав болон тендерийн баримт бичгийн тоо-2	0	"Төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд цахим гэрээг нэвтрүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх (нотариат) судалгаа" ЦХИХХЯ/20250203039 дугаартай төслийн ажлыг даалгавар болон тус тендерийг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороо байгуулах тушаалын төслийг тус тус боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын "Үнэлгээний хороо байгуулж, зардал	03.15 07.30	100

	боловсруулж, тендер зохион байгуулна.			гаргах тухай" 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/146 дугаар тушаалыг батлуулсан.		
	Дэд арга хэмжээ 1.4.2. Цахим хэлбэрээр гэрээ байгуулах, хэлцэл хийх, нотариатын үйлчилгээ үзүүлэх, тэдгээрийг баталгаажуулах шийдлийн санал боловсруулсан байна.	Боловсруулсан баримт бичгийн тоо 1	0	Тайлант хугацаа болоогүй	07.20 12.15	Үнэлэх хугацаа болоогүй
Зорилт 2. "ИННОВАЦ, ГАРААНЫ БИЗНЕС, ИХ ӨГӨГДЕЛ, ХИЙМЭЛ ОЮУН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ"						
	Арга хэмжээ 2.1. Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний № 3.1. Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 03 дугаар тогтоолоор "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги" төлөвлөгөө батлагдсан.	Боловсруулсан баримт бичгийн тоо 1	Хууль батлагдсан	Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 03 дугаар тогтоолоор "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги" төлөвлөгөө батлагдсан.	02.15 06.30	100
5.	Дэд арга хэмжээ 2.1.1. Стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, оролцогч талуудаас санал авсан байна.	Стратеги төлөвлөгөөний төсөл, саналын товьёгийн тоо-2	0	Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн хурлыг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж, Үндэсний Зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 02, 03 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгүүдийг эрчимжүүлэх зохион байгуулалтыг хийх зорилгоор ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан. Тус өөрчлөлтийн дагуу Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратегийг боловсруулах ажлын хэсгийн хурлыг 2025 оны 3 дугаар сарын 19, 24, 26-нд, нэмэлт уулзалтуудыг 25, 27-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, олон улсын сайн туршлага, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн	02.15 06.30	100

				баримт бичиг болон урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан, Засгийн газрын 2020 оны 100 дугаар тогтоолоор баталсан Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-ний анхны төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн, 5 зорилтын хүрээнд 37 ажил, арга хэмжээ хэрэгжүүлэх стратегийн төслийг, стратегийн зорилтын шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь болон зорилтот түүшингийн хамт эцэслэн боловсруулсан.		
	Дэд арга хэмжээ 2.1.2. Стратеги төлөвлөгөөний төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 97 дугаар тогтоолоор байгуулагдсан Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.	Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл-1	0	Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний төсөл, түүний танилцуулгыг Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын Хууль эрх зүй, виртуал бүсийн үйл ажиллагааны хэлтсийн даргатай хамтран боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 97 дугаар тогтоолоор байгуулагдсан Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлд 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр танилцуулан, уг төслийг нийт гишүүдийн дийлэнх олонхиын саналаар дэмжин, Зөвлөлийн 03 дугаар тогтоолоор баталсан. Мөн 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралд танилцуулах танилцуулгыг бэлтгэж, тус хуралд оролцсон.	02.15 06.30	100
Зорилт 3. “САЛБАРЫН УРТ, ДУНД БОЛОН БОГИНО ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛНА.”						
6.	Арга хэмжээ 3.1. Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний № 4.2. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний	Боловсруулсан баримт бичгийн тоо 2	Эдийн засаг хөгжлийн яаманд 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/98	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тус яамнаас хариуцсан хэрэгжүүлэх нийт 10 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.	03.15 05.30	100

	төсөлд тусгуулах төсөл, арга хэмжээний тооцоолол хийж, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлнэ.		дугаартай албан бичгээр нийт 13 төслийн санал хүргүүлсэн.			
	Дэд арга хэмжээ 3.1.1. Эдийн засаг, хөгжлийн сайдын "Аргачлал батлах тухай" 2022 оны А/167 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу тус яамнаас хариуцан хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний саналыг нэгтгэн боловсруулж, шалгуур үзүүлэлтийн хамт Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн байна.	Боловсруулсан баримт бичгийн тоо 2	Нийт 13 төслийн санал хүргэгдсэн.	Tус яамнаас 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/98 дугаартай албан бичгээр Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгуулах нийт 13 төслийн саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж, 6 төсөл, арга хэмжээ дэмжигдсэний дагуу ЭЗХЯ-ны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат болон холбогдох албаны хүмүүстэй 2025 оны 3 дугаар сарын 11, 17-ний өдрүүдэд тус тус уулзалт зохион байгуулж, хиймэл оюун, инновацыг дэмжих чиглэлээр 3 төсөл, арга хэмжээг нэмж тусгасан. Мөн Сангийн яамнаас дээр дурдсан 6 төслийг хасах санал гаргасны дагуу холбогдох тайлбар, мэдээллийг нэгтгэн боловсруулж ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд үндэслэн тус яамнаас хариуцан хэрэгжүүлэх нийт 25 төсөл (өмнө дэмжигдсэн 6 төсөл багтсан)-ийн төслийн саналыг шалгуур үзүүлэлт, тайлбарын хамт нэгтгэн боловсруулж, 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 01/916 дугаартай албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн.	03.15 04.25	100
	Дэд арга хэмжээ 3.1.2. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд тусгуулах төсөл, арга хэмжээний танилцуулга, мэдээллийг тухай бүр бэлтгэж, Инновацийн байнгын хороо, УИХ-ын чуулганд	Боловсруулсан баримт бичгийн тоо 1	-	Tус яамнаас Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгуулах төслийн санал, тайлбар, шалгуур үзүүлэлтийн нарийвчилсан мэдээллийг нэгтгэн боловсруулж, Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 15, 05 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит хуралдаан болон УИХ-ын хаврын ээлжит чуулганд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажилласан.	04.25 05.30	100

хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангана.			Mөн Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэхтэй холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны төлөвлөгөөнд туссан 2 тесөл, арга хэмжээ болон шинээр нэмж тусгах 4 тесөл, арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хариуцан хэрэгжүүлэх зарчмын зөрүүтэй саналын томьёол боловсруулж, Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргад хүргүүлсэн.		
------------------------------------	--	--	--	--	--

Зорилт 4. “ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРЧИМЖҮҮЛЖ, СУДАЛГАА ХӨГЖЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛНА”

7.	Арга хэмжээ 4.1. Газрын үзүүлэгэлийн төлөвлөгөөний № 6.4. Тоон гарын үсгийн хэрэглээний судалгаа хийж, зөвлөмж боловсруулна.	Судалгааны тоо 1 Зөвлөмжийн тоо 1	Тоон гарын үсгийн нэвтрэлтийн талаарх судалгаа 2023 онд хийгдсэн.	Тоон гарын үсгийн хэрэглээний өнөөгийн байдлын суурь судалгааг эхлүүлсэн байна.	03.15 09.30	100
	Дэд арга хэмжээ 4.1.1. ЦХИХХЯ/20250603060 дугаартай “Тоон гарын үсгийн хэрэглээний судалгаа хийж, зөвлөмж боловсруулах” төслийн ажлын даалгаврыг боловсруулж, тендер зохион байгуулна.	Батлагдсан ажлын даалгаврын тоо 1 Батлагдсан гэрээ	-	<p>“Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө”-д туссан “Тоон гарын үсгийн хэрэглээний судалгаа хийж, зөвлөмж боловсруулах ЦХИХХЯ/20250603060” төслийн ажлын даалгаврыг боловсруулж, 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.</p> <p>Мөн тус тендерт үнийн санал авахаар нийт 3 байгууллагад 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 02/743 дугаартай албан бичгийг хүргүүлж, хамгийн бага харьцуулах үнийн санал ирүүлсэн байгууллагатай хийх гэрээний төслийг боловсруулан, Төрийн нарийн бичгийн даргын “Гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай” 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/115 дугаартай тушаалыг батлуулсан.</p>	03.15 05.30	100

				Улмаар тус гэрээний гүйцэтгэлийн тайланг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 05/22 дугаартай албан бичгээр хүлээн авч, хянан нэмэлт судалгаа, мэдээлэл авах тухай албан шаардлагыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр тус төслийг хариуцан ажиллах ерөнхий менежер Б.Амартувшинд албаны цахим шуудан(chinguunkhuslen@gmail.com)-аар хүргүүлсэн. “Тоон гарын үсгийн хэрэглээний судалгаа хийж, зөвлөмж боловсруулах ЦХИХХЯ/20250603060” төслийн гүйцэтгэлийн эцсийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 06/05 дугаартай албан бичгээр хүлээн авч, 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр гэрээ дүгнэн акт үйлдэж, баталгаажуулав.		
	Дэд арга хэмжээ 4.1.2. Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх талаар зөвлөмж боловсруулна.	Боловсруулсан зөвлөмжийн тоо 1	0	Тайлант хугацаа болоогүй	07.20 09.30	Үнэлэх хугацаа болоогүй
8.	Арга хэмжээ 4.2. Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний № 6.5 Төрийн байгууллагуудад ашиглаж буй мэдээллийн технологийн шийдэл, системүүдийн нэгдсэн судалгаа хийж, зөвлөмж боловсруулна.	Судалгааны тоо 1 Зөвлөмжийн тоо 1	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох дүрэм, журам батлагдсан.	Тайлант хугацаа болоогүй	08.05 11.30	Үнэлэх хугацаа болоогүй
	Дэд арга хэмжээ 4.2.1. Төрийн байгууллагуудад ашиглаж байгаа мэдээллийн системүүдийн нэгдсэн судалгаа хийнэ.	Судалгааны тоо 1	Тус яамны харьяа болон салбарын байгууллагаас хувийн хэвшилтэй	Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн “Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах” ЦХИХХЯ/20250103058 төслийн ажлын даалгаварт “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан	08.05 10.30	Үнэлэх хугацаа болоогүй

		хамтран хэрэгжүүлэх боломжтой үйлчилгээ, мэдээллийн системийн талаар санал авсан	мэдээлэл хариуцагчийн ашиглаж байгаа, шинээр хөгжүүлж байгаа болон хөгжүүлэхээр төлөвлөсөн мэдээллийн систем, мэдээллийн сан, мэдээллийн сүлжээний нэгдсэн судалгааг сүүлийн 3 жилээр гаргаж, төсөвт өртөг болон давхардлыг тогтоох” гэсэн ажлыг тусгасан болно.		
Дэд арга хэмжээ 4.2.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбараас үзүүлж байгаа төрийн үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлэх санал, зөвлөмж боловсруулна.	Санал, зөвлөмжийн тоо 1	“Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоол батлагдсан.	Тайлант хугацаа болоогүй	10.30 11.30	Үнэлэх хугацаа болоогүй

НЭМЭЛТ АЖИЛ (хэрэгжилтээр)

Д/д	Үүрэг	Тушаал	Ажлын хэсгийн үүрэг	Тайлбар, явц	Хугацаа	Хувь
9	АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧИГ	Ухаалаг засаг II төсөл Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 сарын 07-ны Ажлын хэсэг	“Цахим шилжилтийг хийхэд шаардлагатай дүрэм журмуудын хийдэл, зөрчлийг тогтоож, санал боловсруулах зөвлөх үйлчилгээ төсөл”-ийн гэрээт ажлын явц болон гүйцэтгэлийн тайланг хянан баталгаажуулах	Төслийн эхлэлийн тайлан болох “Ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө”, Дундын тайлан болох Олон улсын туршлагын судалгааг тус тус хянан, баталгаажуулах хурлыг сар бурийн 15, 30-ны өдрүүдэд зохион байгуулж, Дэлхийн банкны төсөл хариуцсан албан хаагчид албажуулан хүргүүлсэн. Тодруулбал:	02.01 09.01	100

	байгуулах тухай A/30 дугаар тушаал		<ul style="list-style-type: none"> ○ Тус төслийн ажлын даалгавартай танилцаж, ажлын хэсгийн анхны хурлыг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан. ○ Төслийн эхлэлийн тайлантай танилцаж, хурлын тэмдэглэл, ажлын хэсгийн санал, дүгнэлтийн төслийг боловсруулан, ажлын хэсгийн гишүүд болон Гүйцэтгэч, Захиалагчаар баталгаажуулсан. ○ Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг тусгасан эхлэлийн тайланг танилцуулах, Захиалагчаар баталгаажуулах уулзалтыг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан ○ “Дундын тайлан-1:Олон улсын туршлагын судалгаа”-ны тайланг хянан, баталгаажуулж, 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Дэлхийн банкны төсөл хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Болормаад цаасан хэлбэрээр хургуулсэн. 		
10	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 сарын 28-ны өдрийн “Үнэлгээний хороо байгуулах, зардал гаргах тухай” A/118 дугаар тушаал	Төрийн үйлчилгээг цахимаар авахад иргэдэд тулгарч буй хүндрэл эрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулах төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах	Төслийн тендерийн баримт бичиг боловсруулах үнэлгээний хорооны хуралд 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр оролцож, уг тендерийг 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан.	04.25 09.01	100
11	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны A/55 дугаар тушаал	Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө тухайн үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт боловсруулах	Мэдээлэл хариуцагч 6 байгууллагаас ирүүлсэн нийтийн мэдээллийн системд хариуцсан чиг үүргийн хүрээнд зөвлөмж, дүгнэлт боловсруулж, Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем (isr.gov.mn)-ээр дамжуулан баталгаажуулсан.	03.01 09.01	100

		Төрийн нарийн бичгийн даргын "Яамны Ёс зүйн дэд хороо байгуулах тухай" 2024 оны A/126 дугаар тушаал	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, яамны удирдах болон гүйцэтгэх, харьяа байгууллагын Ёс зүйн дэд хорооны албан хаагчид төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг сахиулах талаар зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах	<p>Тус яамны Ёс зүйн дэд хорооны гишүүд өөрчлөн зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан тус зөвлөлийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 02, 23, 24-ний өдрүүдэд тус тус зохион байгуулж, зөвлөлийн гишүүд болон гомдол мэдээлэлтэй холбоотой тайлан мэдээг Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем (https://hrm.csc.gov.mn)-д бүртгэсэн. Мөн харьяа байгууллагаас ирүүлсэн гомдлыг хянан шалгах ажиллагааг зохион байгуулж, тус гомдолтой холбоотой баримт, нотолгоог бүрдүүлэн, Ёс зүйн хорооны дүгнэлтийн төслийг боловсруулж байна.</p> <p>Мөн "Ёс зүйн дэд хороо"-ны албан хэрэглээнд ашиглах хэвлэмэл хуудасны эх загварыг хянан баталгаажуулж, хэвлүүлэх тухай албан бичгийг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 02/809 албан бичгээр Архивын ерөнхий газарт хүргүүлсэн.</p>	04.01 06.30	80
13	АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮН	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн A/10 дугаар тушаал	Мэдээлэл, харилцаа холбооны салбарын төрийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг сонгон шалгаруулах	Засгийн газрын 2023 оны 84-р тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын дагуу харилцаа холбооны салбарын төрийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн гишүүнд тавигдах нийтлэг болон тусгай шаардлага, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үе шат, тэдгээрийг дүгнэх баримт бичгийн төсөлд санал боловсруулж, 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн А.Молор (molor@pcsp.gov.mn)-т цахим хэлбэрээр хүргүүлсэн.	02.01 04.01	100

			Mөн Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”ын 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн харилцаа, холбооны салбарын “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүн, “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг сонгон шалгаруулах ажиллагаанд хариуцсан чиг ургийн хүрээнд оролцсон.		
14	Төрийн нарийн бичгийн даргын “Хяналт-шинжилгээ, үнэлгээ зохион байгуулах тухай” 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн A/59 тушаал	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн болон төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Монголын цахилгаан холбоо ХК-ийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа техник, тоног төхөөрөмжийн өнөөгийн хэрэгцээ шаардлага, насхилт, тэдгээрийг хууль тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу худалдан авсан эсэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор холбогдох хяналт шалгалтыг Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Ш.Самданжамцтай хамтран хийж, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулж, ажлын хэсэгт танилцуулан, хүлээлгэн өгсөн.	02.01 04.01	100
15	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2024 оны A/23 дугаар тушаал	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн туршилтын бүс байгуулах талаар холбогдох судалгаа хийх, туршилтын бүсийн байршлыг тодорхойлох, бүсийг байгуулахад шаардлагатай дүрэм, журмын төслийг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны A/23 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийг шинэчлэх тушаалын төслийг боловсруулан Инновацын бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 208 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийслэлийн Баянзүрх, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах 470 46° 23.44'N, 1070 12° 8.65'E байршилд болон Дархан-Уул аймгийн нутагт дэвсгэрт хамаарах	01.15 02.15	100

			490 28° 47.83'`N, 1050 51° 23.24'`E байршилд дрон туршилтын бус байгуулах боломжтой 1га-10га хүртэлх хэмжээтэй газрын мэдээллийг ирүүлэх тухай албан хүсэлтийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03/154 албан бичгээр хүргүүлсэн ба тус ажил чиг үүргийн дагуу Инновациын бодлого, зохицуулалтын газарт шилжсэн болно.		
16	Төрийн нарийн бичгийн даргын “Эцэг, эхийн зөвлөл шинэчлэн байгуулах тухай” 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/145 дугаар тушаал	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны хүүхэд хамгааллын бодлогыг тодорхойлох, Эцэг эхийн зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах, гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	Тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн албан тушаалын нэр, ангилал, зэрэглэл, орон тоог баталсантай холбогдуулан яамны хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах чиг үүрэг бүхий Эцэг эхийн зөвлөлийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/145 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан арга хэмжээг бусад, газар нэгжийн төлөөлөлтэй хамтран зохион байгуулсан.	05.20 05.30	100
17	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2024 оны тушаал А/45	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төсөл боловсруулах	Ажлын хэсгийн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит хуралд оролцож, хариуцсан асуудлаар санал боловсруулж оролцсон.	01.15 11.30	100
18	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын “Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай” 2023	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөл	Өөрийн хариуцсан чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөнд санал боловсруулж оролцсон. Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдэх, хөгжих эрхийг хангах ажлын хүрээнд iOS үйлдлийн системийн “Text to speech”-д Монгол хэлийг оруулах талаарх суурь судалгааг хийх”	01.15 06.30	100

		оны А/63 дугаар тушаал		төслийн ерөнхий мэдээллийг боловсруулж, тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн ажил, арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах санал гаргаж, батлуулсан.		
19		Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2025 оны А/104 дүгээр тушаал	ЦХИХХЯ/20250102002 кодтой Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх "BPF-24mn дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанад нэвтрүүлэх" тендер шалгаруулах	Тус тендерийн баримт бичиг боловсруулах Үнэлгээний хорооны хуралд 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр, тендерийг үнэлэх хуралд 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр чиг үүргийн хүрээнд санал өгч оролцсон ба шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул уг тендерийг дахин зарлах шийдвэр гарсан. Гэвч Хил хамгаалах ерөнхий газраас тус тендерийг нууцын журмаар зохион байгуулах хүсэлт ирүүлсний дагуу уг тендерийг нууцын журмаар зохион байгуулах асуудал хэлэлцэгдэж байна.	01.15 09.30	100
20	УХААЛАГ ЗАСАГ II ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГ-ЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСЛИЙН ТЕНДЕРИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ГИШҮҮН	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн "Үнэлгээний хороог шинэчлэн байгуулах тухай" А/142 дугаар тушаал	Үндэсний дата төв болон нөөц төвийг клауд буюу үүлэн тооцооллын платформ болгон шинэчлэх төслийн тендерийн хянан үзэх, үнэлэх, захиалагчид шийдвэр гаргах зөвлөмж хүргүүлэх	Тендерийг үнэлэх үнэлгээний хорооны 2 удаагийн хуралд оролцож, тендерийн үнэлгээг гишүүн тус бүр үнэлэн, захиалагчид хүргүүлэх зөвлөмжид гарын үсэг зурж баталгаажуулсан.	01.15 09.30	100
21		Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн "Үнэлгээний хороог шинэчлэн байгуулах тухай" А/143 дугаар тушаал	"Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийн суурь системийг шинэчлэх" төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах	Тендерийг үнэлэх үнэлгээний хорооны 2 удаагийн хуралд оролцож, тендерийн үнэлгээг гишүүн тус бүр үнэлэн, захиалагчид хүргүүлэх зөвлөмжид гарын үсэг зурж баталгаажуулсан.	01.15 09.30	100
22		Төрийн нарийн бичгийн даргын	"Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв	Тендерийг үнэлэх үнэлгээний хорооны 2 удаагийн хуралд оролцож, тендерийн үнэлгээг	01.15 09.30	100

		2024 оны 12 сарын 24-ны өдрийн Үнэлгээний хороо байгуулах тухай дугаар тушаал	байгуулах/тоног төхөөрөмжийг нийлүүлэгчийг сонгон шалгаруулах	гишүүн тус бүр үнэлэн, захиалагчид хүргүүлэх зөвлөмжид гарын үсэг зурж баталгаажуулсан.		
23		Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 сарын 24-ны өдрийн Үнэлгээний хороо байгуулах тухай A/... дугаар тушаал	"Монголын интернэтийн харилцан холболтын төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах" төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах	Тендерийг үнэлэх үнэлгээний хорооны 2 удаагийн хуралд оролцож, тендерийн үнэлгээг гишүүн тус бүр үнэлэн, захиалагчид хүргүүлэх зөвлөмжид гарын үсэг зурж баталгаажуулсан.	01.15 09.30	100
24		Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 сарын 24-ны өдрийн Үнэлгээний хороо байгуулах тухай A/... дугаар тушаал	"Үүлэн тооцооллын үйлчилгээг ашиглах судалгаанд техник эдийн засгийн үнэлгээ хийх техникийн туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ"-ний	Тендерийг үнэлэх үнэлгээний хорооны 2 удаагийн хуралд оролцож, тендерийн үнэлгээг гишүүн тус бүр үнэлэн, захиалагчид хүргүүлэх зөвлөмжид гарын үсэг зурж баталгаажуулсан.	01.15 09.30	100
25		Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 сарын 24-ны өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай A/72 дугаар тушаал	Цахим шилжилтийн талаар хууль, тогтоомжийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах зөвлөх үйлчилгээний гэрээт ажлын явцын болон гүйцэтгэлийн тайланг хянан баталгаажуулах	Төслийн эхлэлийн тайлан болох "Сурталчлан таниулах аяны стратеги"-ийн төсөл, дундын тайлан болох "Фокус бүлгийн ярилцлага, хууль сурталчлах ажлын агуулга"-ын төслийг хэлэлцэх 4 удаагийн хуралд оролцож, хариуцсан чиг үүргийн хүрээнд санал дэвшүүлж оролцсон.	01.15 09.30	100
Зорилт 5. “ӨӨРИЙН ХАРИУЦСАН АЖИЛ ҮҮРЭГТ ХАМААРАХ АСУУДЛААР УДИРДЛАГЫГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ, УДИРДАХ ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ”						
26	Арга хэмжээ 4.1. Удирдлагыг өөрийн хариуцсан асуудлын чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангаж, түүний ажилд мэргэжил	Тухай бүр удирдлагыг мэдээллээр хангаж, мэргэжил, арга	0	1. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хийгдсэн ажил болон тус хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой үүсэж байгаа асуудлын талаар мэдээлэл бэлтгэж, Сайд, ТНБД, газар, хэлтсийн дарга нарт тус тус танилцуулсан.	01.15 12.15	100

	арга зүйн туслалцаа үзүүлнэ.	зүйн туслалцаа үзүүлсэн байна.		<p>2. ЗГХЭГ-аас “Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилттэй танилцах уулзалт”-ыг 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөсөнтэй холбогдуулж, тус яамнаас Монгол хэлний тухай хуулийн хүрээнд авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаарх тайланг боловсруулж, ТНБД-д цахим хэлбэрээр хүргүүлсэн.</p> <p>3. Тус яамнаас хүүхдийн эрхийг хангах, хамгаалахтай холбогдсон хууль, тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлан (17 асуултын хүрээнд 43 ажил, арга хэмжээ)-г боловсруулж, ТНБД-ыг мэдээллээр хангаж, 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 03/102 дугаартай албан бичгээр Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд хүргүүлсэн.</p> <p>4. Зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой асуудлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр яаралтай хурал зарласантай холбогдуулж тус ажлын хэрэгжилтийн талаарх тайланг боловсруулж, БТГ-ын дарга Ш.Батзаяатад цаасан болон цахим хэлбэрээр тус тус хүргүүлсэн.</p> <p>5. Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран ажиллах асуудлыг талаар мэдээлэл бэлтгэн Сайд болон Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлсэн.</p>		
27	Арга хэмжээ 4.2. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй боловч цаг үеийн ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаар өгсөн үүрэг	Үүрэг даалгавар гүйцэтгэсэн байна.	0	<p>1. Монгол Улсын Их Хурлаас Монгол хэлний тухай хуулийг 2015 онд батлан гаргаж, 10 жилийн хугацаанд холбогдох бэлтгэл хангасны үндсэн дээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна гэж, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв</p>	01.15 12.15	100

	даалгаврыг шуурхай гүйцэтгэнэ.			байгууллага нь энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагын баталсан кирилл болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлэг хийх, зөв бичих дүрмийн алдаа хянах болон бусад холбогдох программын хэрэглээг нэмэгдүүлэх, цахим орчинд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заасны дагуу "Алдаа шалгагч, бичиг хөрвүүлэгч" программын ажлын даалгаврыг Монгол хэлний үндэсний зөвлөл болон тус газрын ахлах мэргэжилтэн Б.Бадамсүрэнтэй хамтран боловсруулсан.		
28	Арга хэмжээ 4.3. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өрөнхий төлөвлөлт, тэдгээр хамаарах дэмжих систем, сангийн удирдлагын тогтолцоо, холбогдох, дүрэм, журам, зохицуулалтын хэрэгжилтийг хангахад өөрийн хариуцсан асуудлын чиглэлээр мэргэжил арга зүйн туслацаа үзүүлнэ.	Тухай бүр	0	1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 208 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас ашиглах заавар, аргачлалын төслийг И-Монгол Академи УТҮГ-ын холбогдох албан хаагчтай хамтран боловсруулсан. 2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт заасны дагуу тус яамнаас нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнөх үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргадаг үйл ажиллагааны тайлбар болон зөвлөмж, дүгнэлт гаргахад тулгардаг асуудлын талаар нийт 5 хуудас мэдээлэл бэлтгэн ТНБД болон Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Бат-Өлзий нарт 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр цахимаар болон цаасан хэлбэрээр тус тус хургуулсан.	01.15 12.15	100
Зорилт 5. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ"						
29	Арга хэмжээ 5.1. Хариуцсан чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь	Өөрийн хариуцсан чиглэлээр болон Стратеги, бодлого, төлөвлөлтийн газарт хамаарах асуудлын хүрээнд холбогдох	0	1. Хариуцсан асуудлын хүрээнд хамаарах асуудлаар Монгол Улсын Засгийн газрын тогтоол, хурлын тэмдэглэл, Ерөнхий Захирамж, сайдын албан	01.15 12.15	100

	чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ.	мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн баримт, бусад холбогдох материалын тоо		даалгаврын биелэлтийг сар бүр гаргаж, тогтоосон хугацаанд ТЗҮГ-ын тайлан, төлөвлөгөө хариуцсан албан хаагчид хүргүүлж байна. 2. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан ажил, арга хэмжээний биелэлтийг хариуцах асуудлын хүрээнд, тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох газар, нэгжид тухай бүр хүргэн ажилласан. 3. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2020-2025 оны хэрэгжилтийн нэгдсэн тайланд оруулах санал (яамнаас хариуцсан хэрэгжүүлсэн ажлын тайлан нийт 30 хуудас)-ыг боловсруулж, Ерөнхий сайдын ажлын албанад 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр цахим хэлбэр (viber: Una 99190102)-ээр хүргүүлсэн.		
30	Арга хэмжээ 5.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны	Архивд хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо	0	Эхний хагас жилийн байдлаар хөтлөх нэрийн жагсаалтад оруулсан	01.15 12.15	Үнэлэх боломжгүй

	дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь, бүрэн архивлана.			мэдээлэл байхгүй ба ирсэн явсан албан бичиг цахим сан (erp system)-д архивлагдсан болно.		
31	Арга хэмжээ 5.3. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэнэ.	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо	0	Энэ оны эхний хагас жилийн байдлаар гомдол, мэдээлэл ирээгүй байна.	01.15 12.15	Үнэлэх боломжтүй
32	Арга хэмжээ 5.4. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь чанартай гүйцэтгэх, холбогдох нэгж, албан тушаалтанд хургуулнэ.	Өгсөн үүрэг даалгаврын тоо	0	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9, 22.11 дэх хэсгийг тус тус үндэслэн харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагын төслийг Салбарын эрх зүйн орчны шинэчлэл, хуулийн хэлтэстэй хамтран боловсруулж, Сайдын 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А/79 дүгээр тушаалаар батлуулсан ба тус тушаал захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 7258 дугаарт бүртгэсэн.	04.15 06.01	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин		Хүрсэн түвшин	Эхэлсэн, дууссан хугацаа
				4	5		
1	2	3	6	7			
1.	2.1.Хариуцсан ажлын чиглэлээр олон улсаас зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцно.	Оролцсон сургалт, хурал, семинарын тоо-2	0	Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагаас Япон Улсын Токио хотноо 2025 оны 02 дугаар сарын 03-аас 07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Жёндерийн ялгааг арилгах, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хөдөлгөөнт холбооны архитекторын шийдэл боловсруулах" сэдэвт сургалтад хамрагдсан.	01.15 12.15	100	
2.	2.2.Дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцно.	Оролцсон сургалт, хурал, семинарын тоо-2	0	2025 оны 02 дугаар сарын 13 -ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн анхдуугаар хэлэлцүүлэгт оролцсон. 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Кибер аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээний тайлангийн хуралд оролцсон.	01.15 12.15	100	

ТАЙЛАН БИЧСЭН:

Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын ахлах
шинжээч

..... / Ч.Болор-Эрдэнэ/

2025 оны ... сарын ...

ХЯНАН, БАТАЛГААЖУУЛСАН:

Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

..... / Ш.Батзаяат/

2025 оны ... сарын ...